



“ХАС ХААН ББСБ” ХХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “ХАС ХААН ББСБ” ХХК (Цаашид “ББСБ” гэх)-ийн Залгамж халааны бодлого (Цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь Компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, ББСБ-ын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангахад оршино.
- 1.2. Компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, эрх албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд залгамж халааг тодорхойлох хүрээнд энэхүү Бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт дараах албан тушаалтнуудыг ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. ТУЗ-ийн дарга, гишүүд
 - 1.3.2. ТУЗ-ын нарийн бичгийн дарга
 - 1.3.3. Гүйцэтгэх захирал
 - 1.3.4. Зээлийн хорооны гишүүд
- 1.4. ББСБ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог байгуулах замаар Бодлогыг хэрэгжүүлнэ.

Хоёр. ЗАЛГАМЖ ХАЛААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- 2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (цаашид “Хороо” гэх) нь дотоод болон гадаад эх үүсвэрээс эрх бүхий албан тушаалтанд тохирох буюу шаардлага хангасан этгээдийг олж тодорхойлно.
- 2.2. Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.
- 2.3. Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлж, үнэлж дүгнэх замаар Бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4. Хороо нь ББСБ-ын Хүний нөөцийн мэргэжилтэнтэй судалгаа хийх, хамтарсан төлөвлөгөө гаргах замаар хамтарч ажиллана.
- 2.5. Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.
- 2.6. Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх захирал нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

- 2.7. ББСБ-ын бизнес төлөвлөгөөнд заасны дагуу үйл ажиллагааг өргөтгөх тохиолдолд шинээр гарч болзошгүй орон тоог Хүний нөөцийн мэргэжилтэн нь Хороонд санал болгож, орон тоог ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж батлуулна.
- 2.8. Хороо нь ББСБ-ын алсын хараа, зорилго, бизнес төлөвлөгөөний хүрээнд хийгдэх цаашдын өсөлт, хөгжилтөд шаардлагатай албан тушаалтнуудад тохиромжтой нэр дэвшигчид байгаа эсэхэд дүгнэлт өгнө.
- 2.9. Хүний нөөцийн мэргэжилтэн нь Гүйцэтгэх захирлын хамтаар ББСБ-ын ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг гаргах бөгөөд албан тушаал дэвшин ажиллах боломжтой чадварлаг ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.10. ББСБ-ын эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааг бэлтгэхэд шаардлагатай сургалт хөгжлийн дотоод журам, төлөвлөгөөг Хүний нөөцийн мэргэжилтэн нь Гүйцэтгэх захиралтай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд Хороо нь хэрэгжилтэд хяналт тавина.

Гурав. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 3.1. ББСБ-ын эрх бүхий албан тушаалтан нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан болон бусад урьдчилан харах боломжгүй, гэнэтийн шалтгааны улмаас албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд Хороо нь яаралтай хуралдаж орлох этгээдийг сонгож томилно.
- 3.2. Хороо болон Хүний нөөцийн мэргэжилтэн нь хамтран эрх бүхий албан тушаалтны орон тоо гэнэтийн тохиолдлоор суларсан тохиолдолд тухайн албан тушаалд тохиромжтой, томилох боломжтой этгээдийг судалгаа хийж, нэр дэвшигчдийн судалгааг шинэчилнэ.
- 3.3. Гүйцэтгэх захирал нь урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд түүнийг орлон ажиллах этгээдийг Хорооны санал болгосноор ТУЗ томилно.
- 3.4. Гүйцэтгэх захирлаас бусад удирдах албан тушаалтнууд урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд орлон ажиллах этгээдийг гүйцэтгэх захирал томилно.

Дөрөв. БУСАД

- 4.1. Энэ бодлогын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.